Заамар сумын ЗДТГ-ын 13 албан хаагчид Засгийн газрын хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан цахим сургалтад хамрагдаж, Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг албан үйл ажиллагаандаа хэвшүүлсэн байна.

Төв аймгийн Заамар сумын ЗДТГ нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд буюу хөдөлмөрийн тухай хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор Заамар сумын ЗДТГ нь хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох баримт бичигт орсон өөрчлөлтийг оруулж мөрдсөн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Заамар сумын ЗДТГ нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь ЗДТГ-ын даргын 2021 оны 1 дүгээр сарын 15-ны А/02 дугаар тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирч байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Заамар сумын ЗДТГ нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 52,729.7 мянган төгрөгөөр буюу 2,3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Авлага	16,794.1	10,830.4	-5,963.7
Бараа материал	67,645.7	154,234.4	86,588.7
Үндсэн хөрөнгө	3,864,130.7	3,730,776.1	-133,354.6
Нийт хөрөнгө	3,948,570.5	3,895,840.8	-52,729.7
Өр төлбөр	0	0	
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,948,570.5	3,895,840.8	-52729.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,948,570.5	3,895,840.8	-52729.7

Дээрх хүснэгтээс харахад: Өмнөх жилийн төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогыг татан төвлөрүүлсэнийг 16,794.1 мянган төгрөгийг зарцуулах эрх нээлгэн нэмэлт санхүүжилтийн дансанд авч зарцуулсан бөгөөд тайлант оны зарцуулаагүй үлдсэн 10,830.4 мянган төгрөгийг дараа онд эрх нээлгэн захиран зарцуулахаар авлагаар тусган татан төвлөрүүлсэнтэй холбоотой авлагын үлдэгдэл 5,963.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 67,645.7 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 175,745.9 мянган төгрөгийн бараа материал авч, бусад хангамжийн материалын дансанд ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн 17,555.0 мянган төгрөгийн хаягжуулалт, ХХААГ-аас 5,000.0 мянган төгрөгийн 20 хурган хуцыг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 108,145.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, ажилтнуудад картаар эзэмшүүлж байсан 3,566.9 мянган төгрөгийн бусад хангамжийн материал, аж ахуйн материалыг байгууллагын даргын 2022 оны 2 дугаар сарын 21-ний А/06 дугаар тушаалаар актлаж устгаснаар бараа материалын эцсийн үлдэгдэл 154,234.4 мянган төгрөг болж, 86,588.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Өвөлжилтийн бэлтгэл байдлыг хангах зорилгоор ногоон тэжээл 17,358.2 мянган төгрөгөөр, мод нүүрс 7,500.0 мянган төгрөгөөр, шатахуун 6,881.7 мянган төгрөгөөр бэлтгэн нөөцөлсөн болон зуны 4 хүлэмж 25,000.0 мянган төгрөгөөр, ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн 17,555.0 мянган төгрөгийн хаягжуулалт, ХХААГ-аас 5,000.0 мянган төгрөгийн 20 хурган хуц авсан зэрэг нь бараа материалын үлдэгдлийн өсөлтөд нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 5,378,417.2 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 57,330.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, ОНХС-гийн санхүүжилтээр 50,000.0 мянган төгрөгийн 2 худаг, 49,850.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 13,890.0 мянган төгрөгийн ундны усны худаг цэвэршүүлэх төхөөрөмж зэрэг нийт 113,740.0 мянган төгрөгийн хөрөнгүүдийг үнэ төлбөргүйгээр орлого авч эцсийн үлдэгдэл 5,549,487.2 мянган төгрөг болсон байна.

Тайлант оны хөрөнгийн элэгдлийн зардал 304,424.7 мянган төгрөгөөр бүртгэснээс шалтгаалан хөрөнгийн үлдэгдэл өртөг 133,354.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,895,840.8 мянган төгрөг болж 52,729.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 496,469.0 мянган төгрөг, нийт зарлагыг 496,469.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Заамар сумын ЗДТГ-ын хүргүүлсэн төсвийг 55,520.1 мянган төгрөгөөр бууруулж аймгийн ИТХ-ын 2021 оны 7 дугаар тогтоолоор 440,948.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж ирсэн байна. Сумын ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн 08 тоот тогтоол, 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 06 тоот тогтоолоор 2 удаа тодотгол хийж бичиг хэргийн зардалд 4,980.0 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 50,000.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 20,000.0 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардалд 5,000.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжид 8,371.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 46,930.4 мянган төгрөг, нэг удаагийн шагнал урамшууллын зардалд 1,500.0 мянган төгрөг, тоног төхөөрөмж хөрөнгийн зардалд 222,011.7 мянган төгрөг, их засварын ажилд 759,397.8 мянган төгрөг, нийт 1,118,190.9 мянган төгрөгийн тодотгол оруулж нийт зардлыг 1,559,139.8 мянган төгрөгөөр, зардал санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс бүрэн санхүүжүүлэхээр баталсан байна.

Энэ нь 2022 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй мөн тухайн байгууллагын төсвийн төсөлд хүргүүлсэн саналд үндэслэдэггүй баталдгаас дээд шатны төсвийн

захирагчаас ирүүлсэн төсвийн хязгаарыг 1,118,190.9 мянган төгрөгөөр буюу 3.5 дахин нэмэгдүүлж тодотгол хийсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд аймгийн ИТХ-аас батлагдсан төсөв 440,948.9 мянган төгрөгийг 1,118,190.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2 удаа тодотгосон байна. Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэх 1,538,639.8 мянган төгрөг, хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэх 20,500.0 мянган төгрөг, нийт 1,559,139.8 мянган төгрөгийн зардлыг, орон нутгийн төсвөөс 1,559,139.8 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсны дагуу гүйцэтгэлээр зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 100 хувь олгож, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 695,398.6 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 863,741.2 мянган төгрөг буюу 55,4 хувьтай байгаа нь цалингийн зардлаас 15,559.6 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлээс 3,662.1 мянган төгрөг, тогтмол зардлаас 44.6 мянган төгрөг, албан томилолтын зардлаас 370.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх бараа үйлчилгээний зардлаас 656,1 мянган төгрөг, хөрөнгийн зардлаас 675,106.2 мянган төгрөг, нийт 695,398.6 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	401,198.2	386,190.5	15,007.7	96.3%
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80103- Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	53,253.7	52,605.8	647.9	98.8%
3	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80106- Баг, хорооны үйл ажиллагааны зардал	72,602.9	67,966.1	4,636.8	93.6%
4	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	15,175.5	15,175.5		100%
5	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80918- Бусад	956,409.5	281,303.3	675,106.2	29.4%
6	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 81102- Орон нутгийн нөөц хөрөнгө	35,000.0	35,000.0		100%
7	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 82801- Улсын их баяр наадам	5,000.0	5,000.0		100%
8	71411- Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага 82212- Хур хог хаягдал, орчны бохирдол	20,500.0	20,500.0		100%
	Дүн	1,559,139.8	863,741.2	695,398.6	55.4%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Заамар сумын ЗДТГ нь 2022 онд нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ЗДТГ- аас малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх шатахууны зардалд 1,264.1 мянган төгрөг, статистикийн хэлтсээс ээлжит тооллогын болон тандалт судалгааны зардалд 5,089.8 мянган төгрөг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас ажил зуучлалын зардалд 183.0 мянган төгрөг, Засгийн газраас усны үнэ 3,165.6 мянган төгрөг, цахим тендерийн хураамж 1,046.5 мянган төгрөг, өмнөх оны татан төвлөрүүлсэн нэмэлт санхүүжилтийн орлого 16,794.1 мянган төгрөг, нийт 27,543.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас сумын төвийн бохирын нэгдсэн шугамыг цэвэрлүүлж, лагийг соруулсан зардалд 2,400.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 1,867.8 мянган төгрөг, буудал, сургуулийн сантехникийн шугам засах, цэцэрлэгийн дээврийн урсгал засварын зардалд 6,892.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 5,272.8 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 279.2 мянган төгрөг, нийт 16,712.7 мянган төгрөгийг зарцуулж тайлагнасан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд зарцуулагдаагүй үлдсэн 10,830.4 мянган төгрөгийг татан төвлөрүүлж, дараа онд буцаан авч зарцуулахаар шийдвэрлэн санхүүгийн тайланд авлагаар тусгасан байна.

Нэмэлт санхүүжилтийн орлого, зардлыг зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.5 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт хоёр хөтөлбөрийн найман арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022.01.01-2022.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	Хэрэгжилт 54.8%	1,538,639.8	843,241.2
2	71411- Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	2022.01.01-2022.12.31	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	Бүрэн хэрэгжсэн, биелэлт 100%	20,500.0	20,500.0
Нийт төсвийн дүн					1,559,139.8	863,741.2

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын тамгын газрын 70106 хөтөлбөр 54,8% буюу 695,398.6 мянган төгрөгөөр дутуу хэрэгжсэн нь 80918 арга хэмжээний хөрөнгийн зардал дээр тендер зарлах үйл ажиллагаа хугацаа хоцорсноос болж бараа, ажил үйлчилгээ үзүүлэх гэрээний ажлууд удааширч 29,4 хувьтай дутуу гүйцэтгэгдсэнтэй холбоотой байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 2/09 тоот албан бичгээр Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Заамар сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн баталсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Заамар сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийн нийт зарлага 1,559,139.8 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 23,387.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 17,540.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага авч хэрэгжүүлсэн ажлын тайланг 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай хамт хавсаргаж, ирүүлсэн.

Тус байгууллагын 2022 оны цалингийн зардлаас 15,559.6 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлээс 3,662.1 мянган төгрөг, тогтмол зардлаас 44,6 мянган төгрөг, албан томилолтын зардлаас 370.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх бараа үйлчилгээний зардлаас 656,1 мянган төгрөг, хөрөнгийн зардлаас 675,106.2 мянган төгрөг, нийт 695,398.6 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг үндсэн үйл ажиллагааны санхүүжилтээс орон нутгийн төсөвт төвлөрүүлж ажилласан байна.

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-д “ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсхүл өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардлыг олгохгүй” байх заалтын дагуу Заамар сумын Засаг даргын тамгын газрын алба хаагчдад 2022 онд замын зардал олгоогүй, хууль тогтоомжид зааснаас бусад хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгоогүй байна.

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2-д “энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох” заалтыг хэрэгжүүлж хөрөнгийн зардлаас 675,106.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөв татан төвлөрүүлсэн байна.
- Тус ЗДТГ-т чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоосон тохиолдол гараагүй Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох” заасны дагуу хэрэгжилтийг хангаж ажиллан, цалингийн зардлаас 15,559.6 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлээс 3,662.1 мянган төгрөгийг хэмнэж орон нутгийн төсөв татан төвлөрүүлсэн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д “хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх” гэж заасны дагуу нэмэлт санхүүжилтийн данснаас сумын төвийн бохирын нэгдсэн шугамыг цэвэрлүүлж, лагийг соруулсан зардалд нэмэлт санхүүжилтийн данснаас 2,400.0 мянган төгрөгийг шилжүүлж, өр төлбөрийн тооцоог дотоод эх үүсвэрээс барагдуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад тендер худалдан авах ажиллагааны 9 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 12 орлогын, 34 зарлагын мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 23 шийдвэрийг хугацаанд нь байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн 1 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 2/97 тоотой ирүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	5,200.0	1	5,200.0	100%
Албан шаардлага	2	35,748.0	2	35,748.0	100%
Зөвлөмж	1	653.0	1	653.0	100%
Нийт дүн	4	41,601.0	4	41,601.0	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын тамгын газрын дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлын эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн 695,398.6 мянган төгрөгөөр тохируулаагүй, нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайланг өмнөх үеийн гүйцэтгэл 53,928.7 мянган төгрөгтэй зэрэгцүүлэхүйц байх зарчмыг хангаж тайлагнаагүйгээс нийт 749,327.3 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залрууллаа.

Аудитаар нийт 26,301.0 мянган төгрөгийн 2 зөрчил илэрсэнд зөрчлийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага хүргээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1.Илрүүлэлт:

Сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/331, А/332 тоот захирамжуудаар сумын болон аймгийн 2022 оны хөдөлмөрийн аварга 1 байгууллага, 41 хүнд 12,650.0 мянган төгрөгийн шагнал урамшуулал, 4 багийн 64 өрхөд 7,450.5 мянган төгрөгийн хүнсний дэмжлэг, гирний спортын үйл ажиллагаанд 6,200.0 мянган төгрөгийн аж ахуйн материал, нийт 26,301.0 мянган төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс захиран зарцуулахдаа, үнийн харьцуулалт хийгээгүй, гэрээ байгуулаагүй 1 иргэн, 1 аж ахуйн нэгжээс шууд худалдан авч бэлтгэсэн зөрчил байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д “Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно”, 33.2.2-д “техникийн болон бусад нөхцөл шаардлагыг хангаж байгаа хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид энэ хуулийн 29.1-д заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй бөгөөд санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Худалдан авалтын журмыг мөрдөх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2.Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1.Илрүүлэлт:

Тус тамгын газрын үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайланд дурдагдсан зарим ажлууд өмнөх онд гүйцэтгэгдсэн, тайлант онд зардал зарцуулж хэрэгжүүлсэн ажлууд тайлагнагдаагүй бөгөөд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг 440,948.9 мянган төгрөгөөр дээд шатны төсвийн захирагчаас

баталсныг 1,118,190.9 мянган төгрөгөөр буюу 3.5 дахин нэмэгдүүлж 2 удаа тодотгол хийж, төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.1-д “Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагыг хангах”, 6.5.4-д “төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах” гэсэн заалтуудтай нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх”, “оршин байх”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулж, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг тооцоолох

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

мянган төгрөгөөр

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуул- сан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
							залруулсан		залруулаагүй			
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлын эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн 695,398.6 мянган төгрөгөөр тохируулаагүй, нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайланг өмнөх үеийн гүйцэтгэл 53,928.7 мянган төгрөгтэй зэрэгцүүлэхүйц байх зарчмыг хангаж тайлагнаагүйгээс нийт 749,327.2 мянган төгрөгийн алдаа илэрсэн	1	749,327.3			1	749,327.3	1	749,327.3				

мянган төгрөгөөр

Алдааны товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Сумын засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/331, А/332 тоот захирамжуудаар 26,301.0 мянган төгрөгийг засаг даргын нөөц хөрөнгөнөөс захиран зарцуулахдаа, үнийн харьцуулалт хийгээгүй, гэрээ байгуулаагүй зөрчил байна.	1	26,301.0					1	26,301.0				
Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг тусгасан төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй зөрчил байна.	1	-					1	-				
Дүн	1	26,301.0	0	0.0	0	0.0	1	26,301.0	0	0.0	0	0.0

мянган төгрөгөөр

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	0	0	0	0	0	0	0	0